

БАТЛАВ:  
ЗДТГ-ЫН ДАРГА

А.МӨНХТУУЛ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМАНД БОГИЙН ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН  
ӨВӨЛЖӨӨ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.03.01

Эх сүж

Санхүүгийн эх үүсвэр: Орон нутгийн хөгжлийн сан  
Төсөвт өртөг: 24.468.700 төгрөг  
Байршил: Эрдэнэ баг Мухдаг  
Ажил гүйцэтгэх хугацаа: 2024.03.01-2024.08.20

**Зориулалт:** Бог малын хээлтүүлэгч хуц ухныг нэг суурьт төвлөрүүлэн маллах өвөлжөөний зориулалттай байр болон төмөр хийцлэлтэй хашаа, өвс тэжээлийн хашааг доорхи даалгаврын дагуу барьж хугацаанд нь хүлээлгэн өгнө.


**1. Битүү дулаан байр:** 300 толгой бог орох багтаамжтай буюу 220 м<sup>2</sup> талбай бүхий /20\*10,5м дотор зай/, бетонон блокоор /даацын/ ханыг өрж дээврийг рам зангидаж дээврийн төмрөөр дээвэрлэнэ. Дээврийн төмрийн зузаан нь дундаж хэмжээтэй байна. Дээврийн баганууд төмөр шонтой байна. Ханыг өрөхдөө 20-30 см-ийн гүн ухаж пундамент цутгасан байна. Дээврийг дундаа таславчтай буюу дээврээр туссан нарны гэрэл хойд талын ханан дээр тусч байхаар хийж туушд нь шиллэсэн байна. Ханын өндөр 1,8 м, голын дам нурууны өндөр 2,5 м байна. Дээврийн банз битүү тавигдсан байна. Хаалга 1,7 м-ийн өндөртэй, 3 м-ийн урттай, 2 хавтастай, төмөр хийцлэлтэй, бат бэх, хөнгөн, хялбар түгжиж болохуйц түгжээтэй байна. Урд хананы хаалганы 2 талд байнга нар тусч байхаар цонх гаргаж рам зангидан шиллэсэн байна. Цонхны өндөр 60 см, урт нь 150 см, нэг талдаа 3 ш байх ба газраас 1 м-ийн өндөрт байна. Дээшээ, гадагшаа сөхөгдөж салхи оруулах зориулалттай дээрээ нугастай байна. Дээврийн нүүрэн талын нарлагааны цонх нь 18 м урт, өргөн нь 80 см байна. Агааржуулалтын хоолой нь урд талдаа 4 ар талдаа 4 нийт 8 ш байна.

**2. Задгай хашаа:** Хашаа нь зөөвөрлөж барихад зориулсан, эр эм дэгээтэй, нэг хайсны урт нь 2,7 м, өндөр нь 1,2 м, гадна рам нь труба, 3 эгнээ банзны зузаан нь 2,5 см, 22 ш, бат бөх гагнаастай, хүрэн өнгөөр будсан байна.

**3. Өвс, тэжээлийн хашаа:** Өвс тэжээл агуулхад зориулагдсан, урт нь битүү дулаан байрны урттай тэнцүү, өргөн нь 5 м байна. Хашааны хийцлэл бат бөх гагнаастай, 3 м тутамд ф 60 мм-ээс доошгүй диаметртэй труба эсвэл төмөр шонг цутгаж суурилуулсан, бат бөх чанартай тороор хийсэн байна. 1,5 м-ын өндөртэй торыг төмөр шон дээрээ гагнаж тогтоох ба дээд доод ирмэгийг угольник төмрөөр

эмжсэн байна. Аль нэг талдаа /газрын байрлалыг харгалзан сонгоно/ ачааны машин багтаж орохуйц хаалгатай байна. Хаалга нь хялбар түгжиж болох түгжээтэй, бат бөх, онгойж хаахад хөнгөн, шонтойгоо нугасаар холбогдсон байна.

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Ц.ЭНХБОЛД  
МАН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭНИЙ  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.ГАНЧИМЭГ